

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2005 ОНЫ ШҮҮН
ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮНГИЙН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

Нэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 2005 онд 12233 хүнд холбогдох 8231 эрүүгийн хэрэг хүлээн авч, 662 хүнд холбогдох 363 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, шүүгдэгч, хохирогч эвлэрснээр 254 хүнд холбогдох 195 хэргийг, 372 хүнд холбогдох 185 хэргийг цагаатгах тогтоолоор тус тус хэрэгсэхгүй болгож, 10153 хүнд холбогдох 6966 хэргийг таслан шийдвэрлэж, оны эцэст 792 холбогдогчтой 522 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 11.1 хувиар, ял шийтгүүлэгчид 7.2 хувиар өсчээ.

Анхан шатны шүүхээр 2005 онд таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгчдийг өмнөх онтой нь харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Эрүүгийн хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2004 он	2005 он	тоо	хувь	2004 он	2005 он	тоо	хувь
1	Архангай	160	234	74	46.3	249	379	130	52.2
2	Баян-Өлгий	84	89	5	5.95	110	133	23	20.9
3	Баянхонгор	121	113	-8	-6.61	218	185	-33	-15
4	Булган	168	172	4	2.38	224	270	46	20.5
5	Говь-Алтай	108	95	-13	-12	166	154	-12	-7.2
6	Говьсүмбэр	56	68	12	21.4	78	101	23	29.5
7	Дархан-Уул	329	440	111	33.7	523	675	152	29.1
8	Дорнод	175	199	24	13.7	264	286	22	8.33
9	Дорноговь	221	236	15	6.79	318	357	39	12.3
10	Дундговь	116	128	12	10.3	163	197	34	20.9
11	Завхан	146	143	-3	-2.05	220	199	-21	-9.5
12	Орхон	209	188	-21	-10	339	345	6	1.77
13	Өвөрхангай	217	260	43	19.8	339	347	8	2.36
14	Өмнөговь	123	108	-15	-12.2	182	167	-15	-8.2
15	Сүхбаатар	71	92	21	29.6	97	130	33	34
16	Сэлэнгэ	430	497	67	15.6	637	660	23	3.61
17	Төв	251	207	-44	-17.5	383	293	-90	-23
18	Увс	182	228	46	25.3	257	367	110	42.8
19	Ховд	169	162	-7	-4.14	239	219	-20	-8.4
20	Хөвсгөл	245	264	19	7.76	375	372	-3	-0.8
21	Хэнтий	234	257	23	9.83	310	338	28	9.03
22	Нийслэл	2457	2786	329	13.4	3782	3979	197	5.21
	Дүн	6272	6966	694	11.1	9473	10153	680	7.2

байдалтай байна.

Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Завхан, Ховд, Баянхонгор, Орхон, Говь-Алтай, Өмнөговь, Төв аймагт 2.05-17.5 хувиар буурч, Булган, Баян-Өлгий, Дорноговь, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Нийслэл, Дорнод, Сэлэнгэ, Өвөрхангай, Говьсүмбэр, Увс, Сүхбаатар, Дархан-Уул, Архангай аймагт 2.38-46.3 хувиар нэмэгджээ.

Ял шийтгүүлэгчид Хөвсгөл, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Завхан, Баянхонгор, Төв аймагт 0.8-23 хувиар буурч, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорнод, Хэнтий, Дорноговь, Булган, Дундговь, Нийслэл, Баян-Өлгий, Дархан-Уул, Говь-Сүмбэр, Сүхбаатар, Увс, Архангай аймагт 1.77-52.2 хувиар нэмэгджээ.

Шүүхээр таслан шийдвэрлэгдсэн нийт хэргийн 8.4 хувийг онц хүнд, 16.6 хувийг хүнд, 56.4 хувийг хүндэвтэр, 18.6 хувийг нь хөнгөн төрлийн гэмт хэрэг эзэлж байна.

Анхаарал татаж байгаа эрүүгийн хэргийг авч үзвэл:

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчид			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2004 он	2005 он	тоо	хувь	2004 он	2005 он	тоо	хувь
1	Хүнийг санаатай алах	253	276	23	9.1	289	312	23	7.9
2	Бусдын бие махбодид хүнд гэтэл санаатай учруулах	285	290	5	1.8	301	311	10	0.3
3	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	2426	2905	479	19.7	4261	4879	618	14.5
4	Танхайрах	710	626	-84	-11.8	1026	896	-130	-12.7
5	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	95	116	21	22.1	216	251	35	16.2
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	496	594	98	19.8	530	617	87	16.4
7	Албан тушаалын гэмт хэрэг	19	23	4	21.1	28	28	-	-
8	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	49	62	13	26.5	77	102	25	32.4

байдалтай байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг нь таслан шийдвэрлэсэн нийт хэргийн 70.2 хувь, ял шийтгүүлэгчдийн 72.8 хувийг эзэлж байгаа бол бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах гэмт хэргийн нийлбэр нь нийт хэргийн 50.7 хувийг эзэлжээ. Харин албан тушаалын 23 гэмт хэрэгт 28 хүн шийтгүүлсний дотор хээл хахууль авсан 1 хэрэгт 4 хүн, хахууль өгсөн 2 хэрэгт 2 хүн, хахуулийг зуучилсан гэмт хэрэгт 1 хүн тус тус шийтгүүлсэн байна.

Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг өнгөрсөн оныхоос 1.8 хувиар, бусдыг санаатай алсан гэмт хэрэг 9.1 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайх гэмт хэрэг 19.7 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 19.8 хувиар, албан тушаалын гэмт хэрэг 21.1 хувиар, дээрмийн гэмт хэрэг 22.1 хувиар тус тус өсч, харин танхайрах гэмт хэрэг 11.8 хувиар буурсан байна.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг авч үзвэл:

Д/д	Үзүүлэлт	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2004 он	2005 он	Тоо	Хувиар
Ял шийтгүүлэгчид. Үүнээс:	Насанд хүрээгүй этгээд	1121	1195	74	6.6
	Эмэгтэйчүүд	735	876	161	19.2
	Гадаадын харъяат	29	55	26	1.8 дахин
	Урьд ял шийтгүүлсэн	2065	2051	-14	-0.6
	Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн	1818	1873	55	3.02
	Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн	2228	2212	-16	-0.7
	Ажил, сургуульгүй хүмүүс	6977	7206	229	3.3

байдалтай байна.

Гэмт хэргийн улмаас нийтдээ 8 тэрбум 472 сая төгрөгийн хохирол учирч, 593 хүний амь нас хохирч, 2499 хүний биед хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учирчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

Д/д	Төрөл	Бүтэн жилд		Нийт ялын дотор эзлэх хувь	
		2004 он	2005 он	2004 он	2005 он
	Нийт ял шийтгүүлэгчид	9473	10153		
1	Хорих ялаар бүгд Үүнээс:	6686	6947	70.6	68.4
	а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	2926	3136		
	б/ Тэнссэн	2886	2915		
	в/ Эрүүгийн хуулийн 62, 63-р зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс:	858	888		
	а/Насанд хүрээгүй этгээд	784	748		
	б/Жирэмсэн эмэгтэй 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	74	140		
	г/ Өршөөл үзүүлсэн	16	8		
2	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн Үүнээс:	2661	3106	28.1	30.6
	а/ Торгох ял	672	745		
	б/ Албадан ажил хийлгэх ял	396	645		
	в/ Баривчлах ял	1593	1716		
3	Онцгой ял /цаазаар авах/	22	31	0.2	0.3
4	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	104	69	1.1	0.7

байдалтай байна.

Ял шийтгүүлэгчдийн 68.4 хувьд хорих, 6.4 хувьд албадан ажил хийлгэх, 16.9 хувьд баривчлах, 0.3 хувьд онцгой ял, 0.7 хувьд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг тус тус оногдуулсны гадна 7.3 хувь буюу 745 хүнд торгох ял оногдуулан тэднээс 2 тэрбум 489 сая төгрөг гаргуулжээ. 3136 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлсэн нь нийт ял шийтгүүлэгчдийн 30.9 хувь, хорих ял шийтгүүлэгчдийн 45.1 хувь болж байна.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 144 хүнд хэрэглэж, тэднээс 31.3 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 456 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

Нийт ял шийтгүүлэгчдийн 4852 буюу 47.8 хувьд хорих ялыг биечлэн эдлүүлсэн ба баривчлах ялаар шийтгэжээ. Хорих ялын биечлэн эдлүүлэх болон баривчлах ялын улсын дундаж хувь дээрмийн гэмт хэрэгт 97.6 хувь, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт 89.0 хувь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт 46.9 хувь, танхайрах гэмт хэрэгт 38.3 хувь, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэгт 62.1 хувь байна.

Шүүх 3136 хүнд оногдуулсан хорих ялын 63.8 хувийг жирийн, 28.3 хувийг чанга, 7.2 хувийг онцгой, 0.7 хувийг гяндангийн дэглэмд эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 2014 хэрэг хүлээн авснаас 1959 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 52.9 хувьд нь тогтоолыг хэвээр үлдээж, 21.5 хувьд нь тогтоолд өөрчлөлт оруулж, 25.6 хувь буюу 501 тогтоолыг хүчингүй болгожээ. Оны эцэст 55 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2004 он	2005 он	2004 он	2005 он	зөрүү /+/, -/
Хянагдсан бүгд	1888	1959			
Хэвээр үлдээсэн	971	1037	51.5	52.9	1.4
Өөрчлөлт оруулсан	420	421	22.2	21.5	-0.7
Хүчингүй болгосон	497	501	26.3	25.6	-0.7
Үлдэгдэл	57	55			

Давж заалдах шатны шүүх 922 тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 47.06 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны шүүх эрүүгийн 878 хэрэг хүлээн авснаас, 213 хэргийг хянаж хариу өгсөн ба 618 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, оны эцэст 47 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 54.4 хувийг хэвээр үлдээж, 16.7 хувийг өөрчилж, 28.9 хувийг хүчингүй болгожээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2004 он	2005 он	2004 он	2005 он	зөрүү /+/, -/	
Хянагдсан бүгд	833	831				
Хянаад хүргүүлсэн	241	213				
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	592	618				
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	331	336	55.9	54.4	-1.5
	Өөрчлөлт оруулсан	106	103	17.9	16.7	-1.2
	Хүчингүй болгосон	155	179	26.2	28.9	2.7
Үлдэгдэл	25	47				

Хяналтын шатны шүүх 282 тогтоол, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 33.9 хувийг эзэлж байна.

Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд иргэний 36440 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, 9011 өргөдлийг хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлэх буюу харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлжээ. Иргэний бүгд 24492 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 1202 хэргээр буюу 5.2 хувиар өссөн байна. Оны эцэст иргэний 2937 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Хянан шийдвэрлэсэн нийт 24492 хэргийн 9543 буюу 38.9 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74-р зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 14949 буюу 61.1 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэжээ.

Анхан шатны шүүхээр 2005 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг урьд онтой харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		өсөлт, бууралт	
		2004 он	2005 он	тоо	хувь
1	Архангай	474	822	348	1.7 дахин
2	Баян-Өлгий	600	623	23	3.8
3	Баянхонгор	560	660	100	17.9
4	Булган	541	515	-26	-4.8
5	Говь-Алтай	455	402	-53	-11.6
6	Говьсүмбэр	198	163	-35	-17.7
7	Дархан-Уул	1010	1137	127	12.6
8	Дорнод	967	982	15	1.6
9	Дорноговь	583	492	-91	-15.6
10	Дундговь	370	462	92	24.9
11	Завхан	836	801	-35	-4.2
12	Өвөрхангай	1013	1322	309	30.5
13	Өмнөговь	530	501	-29	-5.5
14	Сэлэнгэ	1736	1926	190	10.9
15	Сүхбаатар	433	476	43	9.9
16	Төв	495	667	172	34.7
17	Нийслэл	8112	8313	201	2.5
18	Увс	575	634	59	10.3
19	Хөвсгөл	1251	1138	-113	-9.0
20	Ховд	618	546	-72	-11.7
21	Хэнтий	891	930	39	4.4
22	Орхон	1042	980	-62	-6.0
	Дүн	23290	24492	1202	5.2

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг Дорнод, Нийслэл, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар, Увс, Сэлэнгэ, Дархан-Уул, Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Төв, Архангай аймагт 1.6-хувиас 1.7 дахин нэмэгджээ. Харин Завхан, Булган, Өмнөговь, Орхон, Хөвсгөл, Говь-Алтай, Ховд, Дорноговь, Говьсүмбэрт 4.2-17.7 хувиар буурсан байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Эрх зүйн харилцааны төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү /+/,/-/
	2004 он	2005 он	2004 он	2005 он	
Нийт иргэний хэрэг .	23290	24492			
Иргэний эрх зүйн маргаан	10799	11082	46.4	45.2	-1.2
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар	5870	7056	25.2	28.8	3.6
Гэр бүлийн эрх зүйн маргаан	2939	2955	12.6	12.1	-0.5
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	591	649	2.5	2.6	0.1
Бусад эрх зүйн маргаан Үүнээс:	3091	2750	13.3	11.3	-2.0
Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар	41	33			
Дампуурлын хуулиар	3	6			
Компаний тухай хуулиар	11	15			
Нийгмийн даатгалын багц хуулиар	122	262			
Патентийн хуулиар	2	8			
Зохиогчийн эрхийн тухай хуулиар	5	2			
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	19	16			
Төрийн албаны тухай хуулиар	6	6			
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар	12	8			
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар	473	251			
Бусад хуулиар	2397	2143			

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаантай хэрэг 45.2 хувийг, гэр бүлийн эрх зүйн маргаантай хэрэг 12.1 хувийг, хөдөлмөрийн эрх зүйн маргаантай хэрэг 2.6 хувийг нь эзэлж байна.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар иргэний 1380 хэрэг хүлээн авснаас 1299 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 43.2 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж, 25.4 хувь нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 31.2 хувь буюу 406 шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 81 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2004 он	2005 он	2004 он	2005 он	зөрүү /+/,/-/
Хянагдсан бүгд	1324	1299			
Хэвээр үлдээсэн	562	562	42.4	43.2	0.8
Өөрчлөлт оруулсан	315	331	23.8	25.4	1.6
Хүчингүй болгосон	447	406	33.8	31.2	-2.6
Үлдэгдэл	42	81			

Давж заалдах шатны шүүх 737 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 56.7 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны шүүх иргэний 875 хэрэг хүлээн авч, 207 -г хянан хариу өгч, 635 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, шийдвэр, магадлалын 42.6 хувийг хэвээр үлдээж, 28.8 хувийг өөрчилж, 28.5 хувийг нь хүчингүй болгож, 33 хэргийн үлдэгдэлтэй байв.

Үзүүлэлт		Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
		2004 он	2005 он	2004 он	2005 он	зөрүү /+/,/-/
Хянагдсан бүгд		953	842			
Хянаад хүргүүлсэн		238	207			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн		677	635			
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	321	271	47.5	42.6	-4.9
	Өөрчлөлт оруулсан	204	183	30.1	28.8	-1.3
	Хүчингүй болгосон	152	181	22.4	28.5	6.1
Үлдэгдэл		38	33			

Хяналтын шатны шүүх 364 шийдвэр, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 43.2 хувийг эзэлж байна.

Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Захиргааны хэргийн шүүхүүд 2005 онд 745 нэхэмжлэл, гомдол хүлээн авч, 38.4 хувь буюу 286 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, 51.8 хувь буюу 386 хэргийг хянан шийдвэрлэжээ.

Оны эцэст 73 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 5 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 18 хэргийн шүүх хуралдааныг хойшлуулж, 50 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

2005 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг шүүх тус бүрээр үзүүлбэл:

Д/д	Шүүх	Захиргааны хэргийн тоо
1	Архангай	9
2	Баян-Өлгий	23
3	Баянхонгор	6
4	Булган	4
5	Говь-Алтай	4
6	Говьсүмбэр	4
7	Дархан-Уул	6
8	Дорнод	15
9	Дорноговь	6
10	Дундговь	1

11	Завхан	29
12	Орхон	8
13	Өвөрхангай	8
14	Өмнөговь	7
15	Сүхбаатар	10
16	Сэлэнгэ	13
17	Төв	10
18	Увс	9
19	Ховд	15
20	Хөвсгөл	18
21	Хэнтий	14
22	Нийслэл	167
	Дүн	386

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл,

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулиар 43, Төрийн албаны тухай хуулиар 52, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар 7, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар 6, Газрын тухай хуулиар 73, Ашигт малтмалын тухай хуулиар 19, Татварын ерөнхий хуулиар 25, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулиар 17 хэрэг тус тус хянан шийдвэрлэжээ. Эдгээр 242 хэрэг нь нийт хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн 62.7 хувийг эзэлж байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах журмаар 170 хэрэг хүлээн авснаас 164 хэргийг хянан шийдвэрлэж, одоо 6 хэргийн үлдэгдэлтэй гарчээ.

Хяналтын шатны шүүх захиргааны 87 хэрэг хүлээн авч, 12-ыг хянан хариу өгч, 64 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, одоо 11 хэргийн үлдэгдэлтэй байна.

Улсын хэмжээгээр захиргааны 386 хэрэг хянан шийдвэрлэснээс давж заалдах болон хяналтын шатны шүүхээс 97 шийдвэр, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянан шийдвэрлэсэн хэргийн 25.1 хувийг эзэлж байна.

Дөрөв. Бусад асуудлаар

Анхан шатны шүүхүүд бүгд 14607 хүнд захиргааны арга хэмжээ авсны дотор 1003 хүнийг 10538.0 мянган төгрөгөөр торгож, 13604 хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Тайлангийн хугацаанд шүүхүүд ялтныг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 2624 материалыг хянан хэлэлцэж, 58 санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 1749 хоригдлыг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 66 хоригдлын хорих ялыг хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 751 хоригдлын дэглэмийг өөрчилжээ.

2005 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 1876 сэжигтнийг албадан саатуулах тухай материалыг хүлээн авч, 1778 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 98 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзажээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 3062 хүнийг сэжигтнээр, 2641 хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 175 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад улсын тэмдэгтийн хураамжид 1 тэрбум 623.4 сая төгрөг, үүнээс анхан шатны шүүх 1 тэрбум 504.2 сая төгрөг, давж заалдах шатны шүүх 77.3 сая төгрөг, хяналтын шатны шүүх 41.8 сая төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэв. Хяналтын шатны шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 38.5 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхүүд нийт 66684 хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн 7524, иргэний 33503, захиргааны 672 хэрэг, захиргааны зөрчил 14607, ялтныг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай 2624 хүсэлт, 7754 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх тухай асуудал хэлэлцсэн байна.

Анхан шатны шүүхийн нэг шүүгч дундажаар 287 хэрэг маргаан шийдвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос 24 хувиар өсчээ.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 1959, иргэний 1299, захиргааны 164 бүгд 3422 хэрэг хянан шийдвэрлэжээ. Энэ шатны шүүхийн нэг шүүгч дундажаар 33 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх буюу Улсын Дээд шүүх иргэний 842, эрүүгийн 831, захиргааны 76, нийтдээ 1749 хэрэг хянан хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Дээд шүүхийн нэг шүүгчид дундажаар иргэний хэрэг 168, эрүүгийн хэрэг 166, захиргааны 15 хэрэг ногдож байна.

Монгол улсын шүүхүүд 5581 өргөдөл, гомдол хүлээн авснаас 5352 буюу 95.9 хувийг шийдвэрлэн зохих хариуг байгууллага, иргэдэд өгсөн ба одоо 229 өргөдөл, гомдлыг хянаж байна.

Ийнхүү анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүү, иргэний хэрэг өсч, анхан болон хяналтын шатны шүүгчид ачаалал ихтэй ажилласан байна.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
СУДАЛГААНЫ ТӨВ